



НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Хан-Уул Эрүүл мэндийн төв (цаашид “Төв” гэх) нь Засгийн газар, Нийслэлийн болон Хан-Уул дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн талаар төрөөс баримталж байгаа бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүүргийн хэмжээнд зохион байгуулах үндсэн үүрэг бүхий Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа Эрүүл мэндийн байгууллага мөн.

1.2. Төв үйл ажиллагаандaa Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, Засгийн газар, Нийслэлийн болон Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн болон Дүүргийн Засаг дарга, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарын шийдвэрүүд болон, энэ дүрмийг тус тус мөрдөж ажиллана.

1.3. Төв үйл ажиллагаандaa Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 4.2-т заасан төрийн албанд баримтлах үндсэн зарчмуудаас гадна төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтална.

1.4. Төв үйл ажиллагааныхаа явц, үр дүнг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга болон Дүүргийн Засаг даргын өмнө хариуцаж, тайлagnана.

1.5. Төв зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд Хаан банкинд харилцах данстай байна.

Хоёр. Төвийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц

2.1. Төвийн үлгэрчилсэн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга тогтооно.

2.2. Төвийн даргыг дүүргийн Засаг даргатай зөвшилцөн Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, төвийн орлогч даргыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөний үндсэн дээр Төвийн дарга тус тус томилж, чөлөөлнө.

2.3.Төв үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд төлөвлөгөөг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга батална.

2.4.Төвийн дарга дэргэдээ байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар түүнд зөвлөх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Зөвлөх баг болон Удирдлагын зөвлөл байгуулан ажиллуулж болно. Зөвлөх баг болон Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Төвийн дарга батална.

2.5.Төвийн дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.5.1.Батлагдсан бүтэц, орон тоо болон хуулиар тогтоосон эрх, хэмжээний хүрээнд ажилтнуудыг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах;

2.5.2.Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг баталж, ажилтнуудын цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох;

2.5.3.Хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, заавар, дүрэм, журам баталж мөрдүүлэх;

2.5.4.Орлогч дарга болон тасаг нэгжийн дарга, эрхлэгч, албан хаагчидтай хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

2.5.5.Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.5.6.Төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах, ажлын байрны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд холбогдох саналаа Нийслэлийн Эрүүл мэндийн газрын болон дүүргийн Засаг дарга, холбогдох бусад байгууллагад тавьж мэндийн газрын дарга байгуулж ажиллах;

2.5.7.Сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил, дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах;

2.5.8.Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх арга хэмжээ авч ажиллах;

2.5.9.Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.5.10.Tасаг нэгжийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулах, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.5.11.Нийслэлийн Эрүүл мэндийн газрын болон дүүргийн Засаг даргаас шилжүүлсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

2.6. Төвийн дарга, албан хаагчид Нийслэлийн болон дүүргийн төрийн захиргааны байгууллагатай Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргаар дамжуулан харилцана.

2.7. Төвийн дарга хууль тогтоомж, Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгавар, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг тогтоосон хугацаанд Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон дүүргийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын газарт тайлагнаж ажиллана.

Гурав. Төвийн үндсэн чиг үүрэг

3.1. Төв нь нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулах арга хэмжээ авах, энэ талаар тандалт судалгаа хийж, урьдчилан сэргийлэх ажлыг дүүргийн хэмжээнд удирдан зохион байгуулах;

3.1.2. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, сургалт, сурталчилгаа явуулах, бие бялдрыг чийрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа нийгэм, эдийн засаг, орчны хүчин зүйлийг судлан тогтоож, арилгах арга хэмжээ авч ажиллах;

3.1.3. Эрүүл мэндийн асуудлаар тасаг нэгжийн дундын зохицуулалтыг хангаж, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд дүүргийн төр, захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, олон нийтийг идэвхтэй оролцуулан хамтарч ажиллах;

3.1.4. Эмнэлгээс шалтгаалсан халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

3.1.5. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дүүргийн төр, захиргааны байгууллага болон иргэдийн идэвхитэй оролцоо, хамтын ажиллагааг дэмжих;

3.1.6. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр хөтөлбөр, төслүүд боловсруулж хэрэгжүүлэх;

3.1.7. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг хамгаалах асуудлыг төвийн хэмжээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

3.1.8. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд дүүргийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж үйлчилгээ, эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийн талаар тавих зорилт, стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;

3.1.9. Төвийн материаллаг бааз, барилга, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, автомашин ашиглалт, засвар үйлчилгээ, нөхөн хангалтыг нэгтгэн зохион байгуулах;

3.1.10. Дүүргийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стратеги, тэргүүлэх чиглэлд нийцүүлэн улсын төвлөрсөн болон дүүргийн төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хөрөнгийг үр өгөөжтэй зарцуулах зарчмыг баримтлах.

3.2. Төв нь эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаар төрөөс баримталж байгаа бодлого, хууль тогтомжийг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1. Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцүүлэн нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг оновчтой зохион байгуулах;

3.2.2. Өрхийн эрүүл мэндийн төвийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн суурь тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, эмнэлзүйн стандарт, удирдамжийн хэрэгжилтийг хангахад мэргэжил арга, зүйн зөвлөгөө өгч ажиллах;

3.2.3. Поликлиник, салбар амбулатори болон хэвтэн эмчлүүлэх тасгийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглах, нэр төрлийг олшруулах, багаж, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, арга зүйн удирдлагаар хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, хөтлөх;

3.2.4. Онош зүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар дүүргийн хүн амд чанарын баталгаа бүхий, нотолгоонд тулгуурласан онош зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

3.2.5. Эх, нярай, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эсэн мэнд амаржихуй, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, тэгш, чанартай, баталгаатай үзүүлэх, эх хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах;

3.2.6. Нутаг дэвсгэрийн хэмжээнд халдварт болон халдварт бус өвчиний тандалт судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион явуулах, өвчин үүсгэж буй халгаат хүчин зүйлийн эсрэг авах арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулж хэрэгжүүлэх;

3.2.7. Эмийн талаар төрөөс баримталж байгаа бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг төвийн хэмжээнд зохион байгуулж, хүн амыг аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах;

3.2.8. Сувилахуйн тусламжтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, биелэлтэд нь хяналт тавих, үр дүнг дүгнэх, сувилахуйн мэргэжилтнийг давтан сургах арга хэмжээ авч, тэдний мэдлэг, мэргэжил, ур чадвар, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.9. Гамшиг, онцгой байдлын үед ажиллах дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудын эрүүл мэндийн болон яаралтай тусlamж, үйлчилгээний бэлэн байдлыг дээшлүүлэх, болзошгүй гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулах;

3.2.10. Эмнэлгийн барилга, тоног төхөөрөмжийн хангамж, засвар үйлчилгээг нэгтгэн зохион байгуулах, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн асуудлыг зохион байгуулах, бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангамжаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, мэргэжлийн удирдлагаар хангамжийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.2.11. Уламжлалт, нөхөн сэргээх анагаах ухааны тусlamж, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

3.2.12. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчилгээг нэгтгэн зохион байгуулах, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн асуудлыг зохион байгуулах, бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангамжаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж байгууллага, иргэд, орон нутгийн удирдлагаар хангаж ажиллах;

3.2.13. Хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, халдварт болон халдварт бус өвчинөөс урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж байгууллага, иргэд, орон нутгийн удирдлагаар хангаж ажиллах.

3.3. Төв нь хяналт, шинжилгээ, үнэлгээ болон эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх, эрүүл мэндийн статистик мэдээллийг нэгтгэн гаргах, мэдээлэх чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1. Тасаг нэгжийн статистикийн мэдээ, тайланг хүлээн авч нэгтгэх, дүн шинжилгээ хийж, холбогдох газруудад тайлагнах;

3.3.2. Дүүргийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлох зорилгоор шаардлагатай судалгаа, шинжилгээг холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэх;

3.3.3. Төвийн үйлчилгээнд мэдээллийн технологийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн нэвтрүүлэх, цахим мэдээллийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;

3.3.4. Поликлиник, салбар амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасгийн үзүүлж байгаа эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хууль тогтоомжийн биелэлтийг хангамжаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж байгууллагаар үүрэг, даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах;

3.3.5. Төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор урт, дунд, богино хугацааны сургалт зохион байгуулах;

3.3.6. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг дүүргийн хэмжээнд төлөвлөж, шаардлагатай мэргэжлийн чиглэлийг тогтоох, эмч, мэргэжилтнүүдийг сургах ажлыг зохион байгуулах;

3.3.7. Дүүргийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, хэрэгжилтийн байдлыг хянах, тайлагнах.

3.4. Төв нь Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад эрхэлсэн асуудлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгнө.

3.5. Төв нь гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

Дөрөв. Хариуцлага

4.1. Энэ дүрмийг зөрчсөн буруутай этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Тав. Бусад зүйл

5.1. Энэ дүрмийг зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

5.2. Энэ дүрэмд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.
